

ХОТЫН СТАНДАРТЫН КОНТЕНТ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|-------------------------|--------------------------|
| Ажлын нэр: | Хотын стандартын контент |
| Ажил гүйцэтгэх хугацаа: | Хуанлийн 14 хоног |

ҮНДЭСЛЭЛ:

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.6. дахь заалтад тусгасан Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлэх зорилт, Нийслэлийн Засаг даргын А/851 дүгээр захирамж “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэх хангуулах төлөвлөгөөнд” тусгагдсан нь хотын стандартын контентийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах үндэслэл болно.

ЗОРИЛГО:

Хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан түгээх зорилготой.

АГУУЛГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

| № | ТӨРӨЛ | ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ | ТАЙЛБАР МЭДЭЭЛЭЛ |
|---|------------------------------------|--------------------------------------|---|
| 1 | Хотын стандартын танилцуулга видео | Хугацаа: 2 минут Чанар: 4к формат | Хотын стандартын талаарх ойлголт, мэдээллийг тодорхойлсон байна. Текст найруулга хийнэ. |
| 2 | Сэдэвчилсэн зохиомжит видео | Хугацаа: 2 минут Чанар: 4к формат | Хотын стандартын сэдвүүдийн талаарх мэдээллийг зохиомжит маягаар дүрсэлсэн байна. Зохиолын найруулга хийнэ. |
| 3 | Богино влог | Хугацаа: 3 минут Чанар: 4к формат | Хотын стандарт хэрхэн хэрэгжиж байгаа талаар бодит мэдээллийг, мэргэжилтний хамт хүргэнэ. |

Найруулгад тавигдах шаардлага:

- Хэл найруулга нь зөв оновчтой байх;
- Монгол хэлний зөв бичих дүрмийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Ажлыг 4 хувь хийж CD хуулж ирүүлэх;

АЖИЛ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Контент боловсруулах ажлыг захиалагч талд дараах үе шаттай тайлагнан ажиллана.

Үүнд:

1. Контентийн эхний хувилбар боловсруулах;
 - Гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор хотын контентийн эхний хувилбарыг захиалагч талд танилцуулан хэлэлцүүлнэ.
2. Захиалагчийн саналыг тусган засварласан эхний танилцуулгаас хойш 4 хоногийн дотор эцсийн хувилбарыг гэрээнд заагдсан хугацаанд захиалагчид эцэслэн хүлээлгэн өгөх.